



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 597

Улаанбаатар хот

Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний
биелэлтийн мөрөөр авч хэрэгжүүлэх
арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 400 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам”-ын 3.6, 4.1, 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 2019 оны биелэлтийн дүнгээр “Сайн” дүгнэгдсэн, хавсралтад заасан төрийн өмчит хуулийн этгээд (эсхүл ажилтан)-ийг холбогдох журамд заасны дагуу шагнаж, урамшуулахыг зөвшөөрсүгэй.

2. Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийн дүнгээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл), Захиргаа, удирдлагын алба (Н.Ганболд)-нд тус тус даалгасугай:

2.1. Гэрээний биелэлтийг дүнгээр газар эзэмших ашиглах эрхийн баталгаажилт, үнэлгээ, шилжилт хөдөлгөөн, үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийн бүртгэл, ашиглалтад илэрч буй зөрчил дутагдлыг арилгах талаар зөвлөмж боловсруулж төрийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлэх, сургалт зохион байгуулах;

2.2. Автотээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээлэл, үл хөдлөх хөрөнгийн ашиглалт, түрээстэй холбоотой судалгаа мэдээллийг шинэчлэх, зөрчил дутагдлыг арилгах ажлыг 2021 онд зохион байгуулах төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх;

2.3. Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлжүүлэх систем”-ийг шинэчлэх төсөл, бодлогын даалгавар боловсруулан, санхүүжилтийг асуудлыг шийдвэрлүүлэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2.4. Төрийн болон орон нутгийн өмчийн захиргааны статистикийн мэдээллийг Үндэсний статистикийн мэдээллийн санд оруулах, холбох ажлыг судлан зохион байгуулах.

3. Төрийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

3.1. Төрийн өмчийн эд хөрөнгийг бүртгэх, шилжүүлэх, актлах, үнэлэх асуудлаарх холбогдох хууль, тогтоомж, журам, захиргааны актыг мөрдөж ажиллах, цаг хугацаанд нь хэрэгжүүлэн ажиллах;

3.2. Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;

3.3. Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн доорх газрын эзэмших, ашиглах эрхийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу баталгаажуулах, үнэлэх, бүртгэлд тусгах, Засгийн газрын 2013 оны 38 дугаар тогтоолын 6 дугаар заалт, 2020 оны 10 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, 2021 оны улсын үзлэг тооллогоос өмнө зөрчлийг арилгах арга хэмжээ авах;

3.4. Авто тээврийн үндэсний төвийн тээврийн хэрэгслийн улсын бүртгэл, мэдээллийн санд бүртгэлтэй өөрийн байгууллагын тээврийн хэрэгслийн мэдээ, мэдээллийг тулган баталгаажуулж, 2021 оны 1 дүгээр улиралд багтаан илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авах.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны ... сарын ...-ний өдрийн ... дугаар тогтоолын хавсралт

**ТӨРИЙН ӨМЧИЙН ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ДҮНГЭЭР
"САЙН" ҮНЭЛГЭЭ АВСАН ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ**

д/д	Аймаг нийслэл	Сум, дүүргийн нэр	Хуулийн этгээдийн нэр	Регистрийн дугаар	Үнэлгээ (хувь)
1	Улаанбаатар	Чингэлтэй	Барилга, хот байгуулалтын яам	9129308	96%
2	Улаанбаатар	Чингэлтэй	Хууль зүй, дотоод хэргийн яам	9131817	97%
3	Улаанбаатар	Сүхбаатар	Гадаад харилцааны яам	9087273	97%
4	Улаанбаатар	Чингэлтэй	Сангийн яам	9131787	98%
5	Улаанбаатар	Чингэлтэй	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	9080988	98%
6	Улаанбаатар	Чингэлтэй	Татварын ерөнхий газар	6097898	98%
7	Улаанбаатар	Чингэлтэй	Ашигт малтмал, газрын тосны газар	5323533	97%
8	Улаанбаатар	Чингэлтэй	Нийгмийн даатгалын ерөнхий газар	9081739	96%
9	Улаанбаатар	Чингэлтэй	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	9128913	96%
10	Улаанбаатар	Чингэлтэй	Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар	9128921	98%
11	Улаанбаатар	Баянгол	Улсын гуравдугаар төв эмнэлэг	9077154	96%
12	Дорноговь	Замын-Үүд	Гаалийн ерөнхий газрын харьяа Дорноговь аймгийн Замын-Үүд сумын гаалийн газар	9027491	98%
13	Завхан	Алдархаан	Иргэний нисэхийн ерөнхий газрын салбар Завхан Доной нисэх буудал	2628546	96%
14	Улаанбаатар	Баянзүрх	Одон орон геофизикийн хүрээлэн	9095349	99%
15	Улаанбаатар	Сүхбаатар	Үндэсний урлагийн их театр	9112391	96%
16	Архангай	Чулуут	Орхон-Чулуут голын сав газрын захиргаа	3008894	98%
17	Улаанбаатар	Сүхбаатар	Үйлдвэрлэл урлалын политехникийн коллеж	9085629	97%
18	Улаанбаатар	Чингэлтэй	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг	6116906	97%
19	Улаанбаатар	Чингэлтэй	Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн алба	5521564	97%
20	Улаанбаатар	Сүхбаатар	Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль	9087087	96%
21	Улаанбаатар	Чингэлтэй	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК	5081092	98%
22	Улаанбаатар	Чингэлтэй	Төрийн банк	5341469	96%
23	Улаанбаатар	Чингэлтэй	Монголын хөрөнгийн бирж ТӨХК	2071096	98%
24	Ховд	Жаргалант	Ховд дулааны станц ТӨХК	4075536	98%
25	Дорнод	Хэрлэн (Сүмбэр)	Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК	2628651	99%
26	Орхон	Баян-Өндөр	Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК	2688417	99%
27	Улаанбаатар	Багануур	Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК	2008904	98%
28	Дархан-Уул	Дархан	Дарханы дулааны сүлжээ ТӨХК	2650061	97%
29	Орхон	Баян-Өндөр	Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК	2688557	97%
30	Улаанбаатар	Багануур	Багануур дулааны станц ТӨХК	2688794	97%
31	Дархан-Уул	Дархан	Дулаан шарын гол ТӨХК	4245636	97%
32	Улаанбаатар	Хан-Уул	Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК	2546191	96%

Д/д	Аймаг нийслэл	Сум, дүүргийн нэр	Хуулийн этгээдийн нэр	Регистрийн дугаар	Үнэлгээ (хувь)
33	Улаанбаатар	Хан-Уул	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК	2685221	96%
34	Увс	Улаангом	ББЭХС ТӨХК	2643472	97%
35	Дархан-Уул	Дархан	Дархан-АЗЗА ТӨХК	2051028	98%
36	Увс	Улаангом	Увс АЗЗА ТӨХК	2002345	98%
37	Дорноговь	Сайншанд	Дорноговь АЗЗА ТӨХК	3306437	97%
38	Өвөрхангай	Арвайхээр	Өвөрхангай АЗЗА ТӨХК	2058243	96%
39	Өвөрхангай	Арвайхээр	Хархорин АЗЗА ТӨХК	2058286	96%
40	Улаанбаатар	Баянзүрх	Монгол кино ТӨААТҮГ	2119811	97%
41	Улаанбаатар	Баянзүрх	Монросцветмет ТӨҮГ	2550466	97%
42	Улаанбаатар	Сонгинохайрхан	Геологийн судалгааны төв ТӨҮГ	2046997	96%
43	Улаанбаатар	Баянгол	Монгол Ус ТӨААТҮГ	5643228	99%
44	Улаанбаатар	Чингэлтэй	Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ	5340659	97%
45	Улаанбаатар	Чингэлтэй	Барилгын хөгжлийн төв ТӨҮГ	5164753	96%